

Э-Сонин

24 дэх дугаар



2014 он 10 сар

WWW.MSE.MN

Мэдээний Тойм



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ҮНЭТ ЦААС МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН
БИРЖИД БҮРТГЭГДЭН,
АРИЛЖИГДАХААР БОЛЛОО**

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРООНООС ГАРГАСАН
ШИЙДВЭРҮҮД**



**ВАЛЮТЫН ФЬЮЧЕРС, ОПЦИОН
АРИЛЖААНЫ ЖУРМЫН
ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ БАЙНА**

**ХЯНАЛТЫН БОЛОН ГИШҮҮНЧЛЭЛИЙН
ЖУРАМ МӨРДӨГДӨЖ ЭХЭЛЛЭЭ**



**МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН
МОБАЙЛ АППЛЕКЕЙШН "APPLE
STORE"-Д БҮРТГЭГДЭЖ
ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН БОЛЛОО**

**ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН
КОРПОРАЦИ, ДЭЛХИЙН БАНК
ГРУППИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ
ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА**



**БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИУДЫН
ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ЗАСГИЙН
ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААР
ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ**

ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- СЗХ-ны тогтоол болон МХБ-ийн Гүйцэтгэх захирлын тушаалын дагуу Засгийн газрын үнэт цаас МХБ-ээр арилжигдахаар боллоо.
- Валютын фьючерс, опцион арилжааны журмын төслийг боловсруулж байна.
- МХБ-ийн Хяналтын болон Гишүүнчлэлийн журам батлагдан гарлаа.
- МХБ-ийн мобайл апплекейшн «Apple Store»-д бүртгэгдэж ашиглахад бэлэн боллоо.
- МХБ-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар Олон улсын корпораци болон Дэлхийн банк группийн төлөөллийг хүлээн авч уулзав.
- Д.Ангар брокер, дилерийн компаниудын төлөөллийг хүлээн авч, Засгийн газрын үнэт цаасны мэдээллийн танилцуулга мэдээлэл хийлээ.
- Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Санхүү менежментийн ангийн 4 курсын оюутнууд МХБ-тэй танилцав.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

- 10-р сарын арилжааны мэдээ

СУРГАЛТ

“Үнэт цаасны зах зээлийн анхан шатны суурь мэдлэг олгох” сургалт 11 дүгээр сарын 24-ний өдөр эхэлнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг утас: 11-313747 /116 дугаараас авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААС МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД БҮРТГЭГДЭН, АРИЛЖИГДАХААР БОЛЛОО

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 10 дугаар сарын 21-ний 389 дугаар тогтоол болон Монголын хөрөнгийн биржийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10-р сарын 23-ны өдрийн 169 дугаар тушаалаар 100.0 тэрбум төгрөгийн үнийн дүнтэй Монгол Улсын Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарлаа.

Сангийн яамнаас ирүүлсэн нөхцөлийн дагуу олон нийтэд санал болгох жижиглэнгийн нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй ЗГҮЦ-ыг долоо хоног бүр МХБ-ээр арилжаалах бөгөөд тус үнэт цаасны хүүгийн хэмжээ нь тухайн долоо хоногт Монголбанкинд арилжигдсан ижил хугацаатай ЗГҮЦ-ны жигнэсэн дундаж хүүгийн хэмжээгээр тогтоогдоно.

Засгийн газрын зүгээс ийнхүү хөрөнгийн зах зээл, түүнд оролцогчдыг дэмжих зорилгоор эрсдэлгүй, татвараас чөлөөлөгдөх, богино хугацаат ЗГҮЦ-ыг хөрөнгийн биржийн арилжаагаар олон нийтэд чөлөөтэй анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжихаар боллоо. Хугацааны хувьд 3 сар, 6 сар, 1 жилийн хугацаатай байх юм.

Монголын хөрөнгийн биржээр арилжигдах 3 сарын хугацаатай Засгийн газрын үнэт цаасны захиалгыг 2014 оны 10-р сарын 29-ний өдрөөс эхэлж эрх бүхий үнэт цаасны компаниудаар авах бөгөөд 2014 оны 11-р сарын 04-ний өдөр эхний арилжаа хийгдэх болно.

ВАЛЮТЫН ФЬЮЧЕРС, ОПЦИОН АРИЛЖААНЫ ЖУРМЫН ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛЖ БАЙНА



Валютын фьючерс, опцион гэрээний арилжааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжаалах бэлтгэл ажлын хүрээнд Дэлхийн шилдэг стандартад нийцүүлэн арилжааны журмын төслийг боловсруулж байна. Манай улсын хувьд энэ төрлийн арилжааг явуулахад зайлшгүй шаардлагатай мэргэжлийн байгууллага болох Дундын эрсдлийн удирдлагын байгууллага буюу Central Counterparty Clearing (CCP) хараахан үүсэн байгуулагдаагүй байгаа юм. Монголын хөрөнгийн бирж нь 2014 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Лондонгийн хөрөнгийн биржтэй байгуулсан стратегийн хамтын ажиллагааны гэрээний хүрээнд тус байгууллагыг шинээр Монгол улсад үүсгэн байгуулахад Лондонгийн хөрөнгийн бирж мэргэжлийн туслалцаа, дэмжлэг үзүүлэхээр харилцан тохиролцсон юм.

Монголын хөрөнгийн бирж нь 2014 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс валютын фьючерс, опцион арилжааны журмын төслийг Төрийн өмчийн 10, хувийн хэвшлийн 20-н аж ахуйн нэгжид “Санхүүгийн эрсдлийн удирдлага ба Валютын гэрээний арилжаа” сэдвийн дор танилцуулга, хэлэлцүүлэг явуулахаар зорин ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар “Монгол Шуудан” ТӨХК, “Дулааны IV цахилгаан станц” ТӨХК-иудад дээрх хэлэлцүүлгийг явуулсан.



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ШИЙДВЭРҮҮД

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ БАЙГУУЛАГДЛАА

Санхүүгийн зохицуулах хорооны дэргэдэх Үнэт цаасны зах зээлийн бодлогын зөвлөл 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хуралдлаа. Уг хурлаар үйл ажиллагааны дүрмийг хэлэлцэн баталсан бөгөөд Бодлогын зөвлөлийн хурлыг 2 сар тутам зохион байгуулж, шаардлагатай тохиолдолд ээлжит бус хурал хуралдуулж байхаар шийдвэрлэсэн. Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 9 дүгээр сарын 18-ны өдрийн “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай 292 дугаар тогтоол гарсантай холбогдуулан уг тогтоолыг хэрэгжүүлэхэд анхаарах зарим асуудлын талаар тодорхой зөвлөмж гаргаж холбогдох байгууллагад хүргүүлээд байна. Тодруулбал, үнэт цаасны арилжааны тооцоо, төлбөр, төвлөрсөн хадгаламжийн байгууллагын чиг үүргийг тусгаарласнаар бүтцийн томоохон өөрчлөлтүүд хийгдэх бөгөөд уг ажлыг хэрэгжүүлэхэд харилцагч, хөрөнгө оруулагчдыг хохироох, төөрөгдөлд оруулах, тогтолцооны гажуудал бий болох зэрэг системийн эсрдэлтэй асуудал үүсгэхгүй байх үүднээс авах арга хэмжээний талаар холбогдох байгууллагад чиглэсэн зөвлөмж гаргалаа. Хорооны дэргэдэх тус Бодлогын зөвлөл нь үнэт цаасны зэх зээлийн хөгжил, бодлого, зохицуулалтын болон бусад шаардлагатай асуудлуудыг хэлэлцэх, тухайн асуудлаар санал, зөвлөмж боловсруулах үндсэн чиг үүрэгтэй болно.

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ТҮТГЭЛЗҮҮЛСЭН КОМПАНИУД

- “Ай Трейд” ХХК
- “Бумбат Шигтгээ” ХХК
- “Капитал Маркет Корпораци” ХХК
- “Очир Капитал” ХХК
- “Санлавмэд” ХХК
- “АБЖЯ” ХХК
- “Таван толгой хишиг” ХХК

ЖУРАМ БОЛОН ГЭРЭЭГЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГЭЭ БҮРЭН БИЕЛҮҮЛЭХ ХҮРТГЭЛ АРИЛЖААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ НЬ ХЯЗГААРЛАСАН ГИШҮҮН КОМПАНИУД

- “Ай Трейд” ХХК
- “Би Би Эс Эс” ХХК
- “Гранд Девелопмент” ХХК
- “Грийт Секьюритис” ХХК
- “Ди Си Эф” ХХК
- “Догсом” ХХК
- “Зэт Жи Би” ХХК
- “Зюс Капитал” ХХК
- “Масдак” ХХК
- “Очир-Эрдэнэ Инвест” ХХК
- “Соёмбо Инвестмент Корпораци” ХХК
- “Эф Си Икс” ХХК

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН КОМПАНИУД

- “Грандлайн” ХХК
- “Туушин Инвест” ХХК
- “Мөнх-Огторгүй” ХХК

КАСТОИАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ АВСАН КОМПАНИ

- “Худалдаа Хөгжлийн Банк” ХХК

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СЭРГЭЭСЭН КОМПАНИ

- “Би Би Эс Эс” ХХК

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛЭЭС ХАСАГДСАН КОМПАНИУД

- “Разноимпекс” ХК
- “Улаанбаатар” ХК
- “Монел” ХК
- “Цасту” ХК
- “Чимбай” ХК
- “Туул Баян” ХК
- “Модлог” ХК

ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААГ НЭЭСЭН КОМПАНИУД

- “Хөвсгөл” ХК



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ШИЙДВЭРҮҮД

ХЯНАЛТЫН БОЛОН ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ МӨРДӨГДӨЖ ЭХЭЛЛЭЭ

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн хурлаар батлагдсан “Хяналт шалгалтын журам” болон “Гишүүнчлэлийн журам”-ыг 2014 оны 10 сарын 03-ны өдөр Санхүүгийн зохицуулах хороо батламжилснаар хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэллээ. МХБ-д шинээр гишүүн элсэх, гишүүний эрхийг түдгэлзүүлэх, сэргээх, цуцлах болон гишүүний үйл ажиллагаатай холбоотой бусад харилцаа нь “Гишүүнчлэлийн журам”-аар, харин биржийн үнэт цаасны арилжааны хяналт шалгалт болон гишүүн үнэт цаасны компани, үнэт цаас гаргагчдын үйл ажиллагаанд тавих хяналттай холбоотой үүсэх харилцаа нь “Хяналт шалгалтын журам”-аар зохицуулагдах болно. Ийнхүү Санхүүгийн зохицуулах хороо дээрх хоёр журмыг батламжилснаар Монголын хөрөнгийн биржээс “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-тай нийцүүлэн шинэчлэх шаардлагатай үндсэн зохицуулалтууд хийгдэж дууслаа.

ОЮУТАН, СУДЛААЧ НАРТ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ ӨГЧ БАЙНА



Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, мэдээллийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх, ханшийн болон арилжааны мэдээллийг цаг хугацаанд нь үнэн бодитой, шуурхай хүргэх зорилгоор МХБ-ийн Гүйцэтгэх захирлын 2014 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн 156 дугаар тушаалаар хөрөнгийн зах зээлийн талаар судалгаа хийж буй оюутан, судлаач нарт арилжааны болон индексийн мэдээллийг үнэ төлбөргүй гаргаж өгөх тухай шийдвэр гаргаад байна. Энэхүү ажлын хүрээнд биржийн зүгээс өөрийн цахим хуудаст арилжааны түүхэн мэдээллийг нэмж байршуулах, мэдээллийн санг баяжуулах ажлуудыг хийж эхлүүлээд байна.



“МОНГОЛ 999 ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИ НЬ “МОНГОЛЫН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦААНЫ 90%-ИЙГ ХУДАЛДАН АВАХ ЭРХТЭЙ БОЛЛОО

“Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-ийн 22.1.1, 22.4 дэх заалтын дагуу хяналтын багцыг худалдан авах санал гаргагч нь СЗХ болон нийтэд зэрэг мэдэгдэж, хувийг биржид ирүүлсний дараа багцын арилжааг зохион байгуулах боломжтой юм.

Иймд дээрх хуулийн холбогдох заалтын дагуу “Монгол 999 Үндэсний нэгдэл” ХКомпани нь “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн эзэмшиж байсан нийт хувьцааны 90%-ийн хяналтын багц хувьцааг худалдан авах санал гаргасныг нийтэд мэдээллэж байна.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН КОРПОРАЦИ, ДЭЛХИЙН БАНК ГРУППИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗЛАА



“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Д.Ангар 2014 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Олон улсын санхүүгийн корпораци, Дэлхийн банк группийн Үйл ажиллагаа хариуцсан мэргэжилтэн Анар Алиевыг өөрсдийнх нь хүсэлтийн дагуу хүлээн авч

уулзлаа. Тус уулзалтын үеэр Монголын хөрөнгийн биржийн явуулж буй үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг өгч, Компанийн засаглалыг сайжруулах чиглэлд хэрхэн хамтарч ажиллах талаар ярилцаж, харилцан санал бодлоо солилцлоо.



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ АЖИЛТАН ШАЛГАРУУЛЖ АВНА

Тавигдах шаардлага

- Мэргэжлийн магадлан итгэмжлэгдсэн дээд сургуулийг төгссөн, бакалавраас доошгүй зэрэгтэй, нягтлан бодогч эсвэл эдийн засагч-нягтлан бодогч мэргэжил эзэмшсэн байх
- Тооцооны нягтлан бодогчоор 5-аас дээш, ерөнхий нягтлан бодогчоор 5-аас дээш жил тус тус ажилласан ажлын туршлагатай, мэргэшсэн нягтлан бодогч байх
- Нягтлан бодох бүртгэл, татварын болон бусад холбогдох хууль, дүрэм журмын талаар мэдлэгтэй байх
- СТОУС болон НББОУС-ын талаар мэдлэг эзэмшсэн, сургалтанд хамрагдсан байх
- Санхүүгийн тайлан төлөвлөлт хийх чадвартай
- Санхүүгийн болон хэрэглээний программ дээр ажиллах чадвартай
- Албан бичиг боловсруулах, судалгаа шинжилгээ хийж дүгнэлт гаргах чадвартай
- Хувийн зохион байгуулалт сайтай, хариуцлагатай
- Харилцааны өндөр соёлтой
- Мэргэжлийн ур чадвар сайтай, тогтвор суурьшилтай, багаар болон бие даан ажиллах чадвартай
- Ял шийтгэлгүй, татварын болон банкны зээлийн өр төлбөргүй байх



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН МОБАЙЛ АППЛЕКЕЙШН “APPLE STORE”-Д БҮРТГЭГДЭЖ ХЭРЭГЛЭХЭД БЭЛЭН БОЛЛОО

Монголын хөрөнгийн бирж нь өдөр тутмын арилжааны болон ханшийн мэдээллийг гар утас болон хөдөлгөөнт төхөөрөмжид зориулагдсан мобайл апплекейшны тусламжтайгаар олон нийтэд хүргэх боломжтой боллоо. Тус программыг ашиглахын тулд App Store-д “**MN Stocks**” гэсэн апплекейшныг татан суулгах хэрэгтэй. Уг программыг ашигласнаар хэрэглэгч ханшийн мэдээллийг 5 минутын хоцрогдолтойгоор хүлээн авахаас гадна өөрийн сонирхсон үнэт цааснуудаар багц үүсгэх боломжтой юм.



ШУТИС-БИЗНЕСИЙН УДИРДЛАГА, ХҮМҮҮНЛЭГИЙН СУРГУУЛИЙН ОЮУТНУУД МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦЛАА



Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Бизнесийн удирдлага, хүмүүнлэгийн сургуулийн М.Сарантуяа багштай Санхүү менежментийн ангийн 4 курсын оюутнууд үнэт цаасны зах зээлийн хичээлээр олж авсан онол, арга зүйн мэдлэгээ батжуулах зорилгоор 2014 оны 9 дүгээр сарын 29-ний

өдөр “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн үйл ажиллагаатай танилцлаа. Оюутнуудыг Зах зээлийн хөгжлийн газрын дарга Ж.Мягмарсүрэн хүлээн авч уулзан, хөрөнгийн биржийн явуулж буй үйл ажиллагааны талаар товч танилцуулга хийж, тэдний сонирхсон асуултанд хариулт өглөө. Оюутнууд Монголын хөрөнгийн биржээр зочилж, арилжааны үйл ажиллагаатай биечлэн танилцсанаар олж авсан мэдээллээр мэдлэгээ бататгах, цаашид судалгааны ажил хийх, үндсэн чиглэлээ сонгоход нь дэмжлэг болсон ажил боллоо.



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОВ ГАРЛАА

“Бинсэ”ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдөр 11:00 цагт хуралдсан. Тус хурлаар өрийг хувьцаагаар солих, нэмж хувьцаа гаргах, хувьцаа хуваах асуудлын талаар ярилцсан байна.



БРОКЕР, ДИЛЕРИЙН КОМПАНИУДЫН ТӨЛӨӨЛЛИЙГ ХҮЛЭЭН АВЧ, ЗАСГИЙН ГАЗРЫН ҮНЭТ ЦААСНЫ ТАЛААР ТАНИЛЦУУЛГА МЭДЭЭЛЭЛ ХИЙЛЭЭ

Засгийн газрын үнэт цаасыг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгийн зах зээлд арилжаалах шийдвэр гарсантай холбогдуулан “Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК, “Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв” ТӨХК хамтран 2014 оны 10 дугаар сарын 24-ний өдөр Брокер, дилерийн компанийн



төлөөллийг хүлээн авч, Засгийн газрын үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоог хэрхэн хийх талаар танилцуулга, мэдээллийг хийж, харилцан санал солилцлоо. 3 сарын хугацаатай Засгийн газрын үнэт цаасны захиалгыг 2014 оны 10-р сарын 29-ний өдрөөс эхэлж эрх бүхий үнэт цаасны компаниудаар авах бөгөөд 2014 оны 11-р сарын 04-ний өдөр эхний арилжаа хийгдэнэ.

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ ЭЭЛЖИТ СУРГАЛТ ӨНДӨРЛӨЛӨӨ



ТӨГСӨЛТИЙН БАЯР

“Монголын Хөрөнгийн Бирж” ТӨХК-ийн “Үнэт цаасны зах зээлийн мэдлэг олгох” анхан шатны ээлжит сургалт 2014 оны 10 дүгээр сарын 27-ноос 31-ний хооронд зохион явагдсан.

Сургалтыг онол-практикийг хослуулан Брокер, дилерийн компанийн үйл ажиллагаатай танилцуулах, арилжаанд оролцуулах хэлбэрээр явуулсан нь суралцагчдын сонирхолд ихэд нийцсэн сургалт боллоо.

Сургалтанд цаашид хамрагдах сонирхолтой иргэд, оюутан залуусын тоо өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрэлт хэрэгцээ их байгаагийн илрэл юм. Иймд бид дараагийн сургалтыг 2014 оны 11 дугаар сарын сүүлээр 24-ний өдрөөс явуулахаар төлөвлөж байна. Энэ удаагийн сургалтанд амжилттай суралцсан 23 суралцагч сертификат гардан авлаа.

Үнэт цаасны зах зээлийн боловсролоо дээшлүүлэх үйлсэд Тань амжилт хүсье



ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ МЭДЭЭ

2014 оны 10 дугаар сар


Арилжааны товч мэдээ

Арилжигдсан ширхэг	797,920
Нийт үнийн дүн	671,919,189.98
Хэлцлийн тоо	782
Арилжигдсан үнэт цаасны тоо	60
Зах зээлийн үнэлгээ	1,557,398,082,348

ТОП-20 индекс

Хаалт	15,547.65
Өмнөх сарын хаалт	15,797.75
Өөрчлөлт /нэгж/	-250.10
Өөрчлөлт /%/	-1.58
52 долоо хоног дээд	17,160.49
доод	13,422.43

ТОП 20 ИНДЕКС



Идэвхтэй арилжигдсан үнэт цаас:

Тоо ширхэгээр:				Үнийн дүгээр:					
№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн	№	Симбол	Үнэт цаасны нэр	Арилжсан ширхэг	Үнийн дүн
1	HBO	ХАЙ БИ ОЙЛ	193,571	75,688,129	1	НАМ	МОНГОЛЫН ХӨГЖ	44,886	157,101,000
2	BHR	БИНСЭ ХК	167,950	103,698,700	2	BHR	БИНСЭ ХК	167,950	103,698,700
3	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	82,160	6,788,748	3	HBO	ХАЙ БИ ОЙЛ	193,571	75,688,129
4	HGN	ХӨХ ГАН	66,979	7,720,403	4	APU	АПУ	15,737	58,374,230
5	ETR	Э-ТРАНСЛОЖИСТИК	46,249	4,380,637	5	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,223	44,476,400

Хамгийн их өсөлттэй үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	TAV	ТАВ	24,140.00	30,500.00	6,360	26.35
2	HVL	ХӨВСГӨЛ	43.71	50.26	7	14.99
3	GFG	ГОВЬФАЙНЕНШЛ ГРУП	448.70	510.00	61	13.66
4	MMK	МАХИМПЕКС	3,295.00	3,719.00	424	12.87
5	BAN	БАГАНУУР	3,501.00	3,799.00	298	8.51

Хамгийн их бууралттай үнэт цаас:

№	Симбол	Үнэт цаасны нэр	Өмнөх сарын хаалт	Хаалтын ханш	Ханшийн өөрчлөлт	
					төгрөг	%
1	MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	5,500.00	4,100.00	-1,400	-25.45
2	RVC	РЕМИКОН	140.00	105.00	-35	-25.00
3	UBH	УЛААНБААТАР ХИВС	16,960.00	14,500.00	-2,460	-14.50
4	SHG	ШАРЬН ГОЛ	7,150.00	6,400.00	-750	-10.49
5	SCI	ЕВРОФЁ АЗИА	3,900.00	3,500.00	-400	-10.26